

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2022/156/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Б.Уранбилэг Утас: 70523020 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Амралт. 2021. 02. 22 № *1-6/77*

танай _____-ны № _____-т

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Тус байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 42,258.4 мянган төгрөгийн 33 нэр төрлийн 36 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Эдгээр хөрөнгүүдийн ашиглах хугацаа 2012-2021 онд дууссан байна. Гэтэл хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх талаар хэмжээ авч ажиллаагүй, жил бүрийн тайланд тусгагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр

зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасныг зөрчиж, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-1 болон үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Бараа материал худалдан авсан ажил гүйлгээний анхан шатны баримтыг шалгахад 7,761.7 мянган төгрөгийн худалдан авалтын э-баримт байхгүй, Сангийн яамны төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх", Нэмэгдсэн өртгийн албаны татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно" гэж заасныг хэрэгжүүлээгүй, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-1 болон иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Тайлант хугацааны эцэст харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж өглөг, авлагыг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчиж, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-1 болон үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
4. Тайлант онд нийт 5,355.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан ба жолоочийн замын хуудас бүрэн бус, гарын үсэг зурагдаагүй, албаны болон хувийн автомашинаар эргүүл хийсэн гэх боловч эргүүлийн хуваарь, тайлан байхгүй, жолоочийн замын хуудсанд нягтлан бодогч тооцоо хийгээгүй, талоноор зарладаж байгаа шатахууны литр тутмын үнэ тодорхойгүйгээс тухайн үеийн шатахуун зарцуулалтад тооцоолол хийх боломжгүй, шатахуун зарцуулалтад хяналтгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны баримт бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.4-т "Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана" гэж заасныг хэрэгжүүлээгүй, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-1 болон үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
5. Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 699.7 мянган төгрөгийг, үндсэн цалингийн зардлаас 714.5 мянган төгрөгийг худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан иргэний нийгмийн байгууллагуудын

төлөөлөл, иргэдэд мөнгөн урамшуулал, урсгал засварын зардлаас 172.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авч эдийн засгийн ангилал зөрчсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-1 болон үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	11.3	10.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,498.8	1,455.9
	Нийт хөрөнгийн дүн	1,510.1	1,466.2
	Нийт өр төлбөрийн дүн	0.09	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,510.1	1,466.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,510.1	1,466.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,680.8	233.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	248.7	272.1
	Үйл ажиллагааны үр дүн	1,432.1	(38.5)
	Үйл ажиллагааны бус үр дүн	28.8	5.3
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,403.3	(43.8)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	106.7	1,510.1
	Тайлант оны үр дүн	1,403.3	(43.8)
	Эцсийн үлдэгдэл	1,510.1	1,466.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	163.5	174.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	161.8	170.8
	Үйл ажиллагааны ЦМГ	1.7	3.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(1.7)	(3.3)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	176.5	170.8
	Урсгал зардал	176.5	170.8
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	169.5	166.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	7.0	4.8

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн өмчийн газрын эрхэм зорилго: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих тайлагнах. Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх

бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Орон нутгийн өмчийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль бусад хууль тогтоомжид заасан холбогдох чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлж ажиллах.
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, бодлогын бусад баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх.
- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хадгалах хамгаалалтыг сайжруулах хяналт шалгалт хийх орон нутгийн өмчийн хөрөнгийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.
- Худалдан авах ажиллагааны талаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үндсэн хөрөнгөд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 42.3 сая төгрөгийн өртөг бүхий 36 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2021 онд туслах үйл ажиллагааны орлогод 7.0 сая төгрөгийн төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 4.8 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Энэ нь тайлант онд цар тахалтай холбоотойгоор зарлагдсан цахим тендер төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйтэй холбоотой байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 58.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.7 сая төгрөгийн алдааг залруулж, 50.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 7.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 42.0 сая төгрөгийн анхны өртөгтэй, үлдэх өртөггүй хөрөнгөнд элэгдэл тооцсоноос үлдэгдэл өртөг хасах 1.7 сая төгрөгөөр тооцсоноос шалтгаалан санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэн байна.

4.2 Албан шаардлага

1. Тайлант хугацааны эцэст харилцагч байгууллагуудтай тооцоо нийлээгүй, өглөг, авлагыг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.
2. Тайлант онд нийт 5.4 сая төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Зарцуулалтыг нэг бүрчлэн авч үзэхэд жолоочийн замын хуудас бүрэн бус, гарын үсэг зурагдаагүй, албаны болон хувийн автомашинаар эргүүл хийсэн гэх боловч эргүүл хийх хуваарь байхгүй, эргүүл хийсэн талаарх тайлан байхгүй, жолоочийн замын хуудсанд нягтлан бодогч тооцоо хийгээгүй, талноор зарладаг байгаа шатахууны литр тутмын үнэ тодорхойгүйгээс тухайн үеийн шатахуун зарцуулалтыг тооцох боломжгүй, тооцоолол хийх боломжгүй, шатахуун зарцуулалтад хяналт байхгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны баримт бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.4-т "Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана" гэж заасныг зөрчсөн байна.
3. Тайлант хугацаанд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 0.7 сая төгрөгийг аймгийн 2020 оны, үндсэн цалингийн зардлаас 0.7 сая төгрөгийг худалдан авах ажиллагаанд үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, иргэдэд мөнгөн урамшууллаар олгосон. Мөн урсгал засвар бичиг хэргийн материал худалдан авахад 0.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн байна.
4. Шилэн дансны нэгдсэн систем дэх мэдээллийг шалгахад 10.7 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай 7 тушаал, байгууллагын батлагдсан төсөв гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг дутуу мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай 6 дугаар зүйлийн 6.1.2-т "Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.4.8-д "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах

санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 7 хоногийн дотор мэдээлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант оны жилийн эцэст нийт 33 нэр төрлийн 36 ширхэг, 42.3 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгөнд ногдох элэгдлийг тооцоогүй байна. Эдгээр хөрөнгүүдийн ашиглах хугацаа 2012-2021 онд дууссан байна. Гэтэл хөрөнгийг хэрхэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, жил бүрийн тайланд тусгагдсан байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасны дагуу тодорхой ажил зохион байгуулж, шийдвэрлэх.

2. Зардлын данстай холбоотой асуудал:

- 2.1. Илрүүлэлт: Бараа, ажил үйлчилгээ худалдан авсан ажил гүйлгээний анхан шатны баримтыг үзэхэд 7.8 сая төгрөгийн худалдан авалтын э-баримт байхгүй, Сангийн яамны төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдээгүй байна..

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх", Нэмэгдсэн өртгийн албаны татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно" гэж заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	7	58.7	1	1.7			4	7.0	2	50.0
	НИЙТ	7	58.7	1	1.7			4	7.0	2	50.0